




ИЛТГЭЛ

Сэдэв: Мэргэлжилтэй ажилтан бэлтгэхэд тулгамдаж
байгаа асуудал

Илтгэгч : Цахилгааны багш Г.Батзул

ГОВЬСҮМБЭР 2020 ОН

Илтгэлийн бүтэц

- Оршил хэсэг
- Үндэслэл
- Үндсэн хэсэг Онолын хэсэг
 - 1.1 Хүүхдийн төлөвшил , хандлага
 - 1.2 Мэргэжлийн ур чадвар сургалтын орчин нөлөөлөх нь
- Судалгааны хэсэг
- Дүгнэлт
- Ном зүй

Оршил

Улсын хэмжээнд 81 МСҮТ, политехник коллеж 225 орчим мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа явуулна. Шинээр 29 мянга орчим суралцагч элсүүлэх тооцоо гаргасан. Орон нутагт үйлдвэр, аж ахуй нэгж төдийлөн элбэг байдаггүйтэй холбоотойгоор мэргэжил эзэмшсэн төгсөгчид нийслэлтэй харьцуулахад шууд ажлын байртай болох нь бага. Гэхдээ зарим аймгийн МСҮТ, политехник коллежийн төгсөгчдийн дийлэнх нь шууд ажлын байртай болж байгаа. Энэ нь ажлын байрны захиалга сургалт сүүлийн үед нэмэгдэж байгаагийн үр дүн. ААН, байгууллагууд нийгмийн түншлэлийнхээ хүрээнд МСҮТ, политехник коллежтой хамтран ажиллаж, сул ажлын байрны тоогоо гаргаж өгснөөр, ажилтандаа тавих шаардлагаа хичээл, сургалтын хөтөлбөрт оруулж, хяналт, үнэлгээ хийж, ур чадвартай мэргэжилтэн сонгон шалгаруулж авдаг болсон. Манай мэргэжлийн боловсрол, сургалтын салбар сүүлийн жилүүдэд энэ зарчим руу шилжиж байгаа.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрт мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт чиглэсэн нэлээд ажил тусгасан. Үүнээс нэн тэргүүнд МСҮТ, политехник коллежуудыг бүсчилж, төрөлжүүлэн хөгжүүлнэ. Хоёрдугаарт, олон тооны МСҮТ, политехник коллеж үйл ажиллагаа явуулахаас илүүтэй төрөлжсөн болон мэргэшсэн болгон хөгжүүлэх нь илүү чанартай, үр дүнтэй гэдэг нь нотлогдсон. Тиймээс мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлж, мэргэшүүлэх талын судалгаанууд хийж, хотхон(кампус) чиглэлээр хөгжүүлэхээр ажиллаж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбар шинэ хичээлийн жилийн зорилгоо **"Чанартай сургалт-Тогтвортой хөдөлмөр эрхлэлт"** хэмээн тодорхойлсон. Чанарыг сайжруулна гэхээр зөвхөн суралцагч, төгсөгчдийн ур чадварт анхаарна гэж ойлгож болохгүй. Салбарын сургалтын чанарыг сайжруулахын тулд суралцагчаас гадна багш, удирдлага, сургалтын орчны чанар, хүртээмжийг сайжруулж, чанарын баталгаажуулалт дээр анхаарч ажиллана.

Үндэслэл

Өнөөгийн эдийн засгийн гол ачааг нуруун дээрээ үүрч буй уул уурхайн салбарыг орлох шинэ боломж бололцоо гэж харж байгаа юм. Энэ салбарыг хөгжүүлэхэд мэргэжилтэй боловсон хүчин нэн шаардлагатай байна. Иймд энэ чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа МСҮТ, коллеж, дээд сургуулийн бүтээгдэхүүнийг чанаржуулах, дадлагажуулах явдал юм.

Иймд нэн тэргүүнд үйлдвэр, ААН, уул уурхайн дээр дадлагажихад үйлдвэрх дээрх дадлагын чанаржуулах, сургалтын төлөвлөгөөнд өөрчилт оруулах, нэгдсэн чадамжинд суурилсан хөтөлбөр мөрдөх явдал юм. Үүний зэрэгцээ орчин цагт чанартай боловсролоор дамжуулан бусдын өмнө хариуцлага хүлээх чадвартай, биеэ даасан бүтээлч хандлагатай иргэн болгон төлөвшүүлэх явдал өнөөдөр тулгамдаж байна.

Иймээс энэ асуудлыг шийдвэрлэхэд мэргэжилтэй ажилтанг бэлтгэхийн тулд сургалтын орчин, суралцагч оюутанг хандлага төлөвшилтэй болгох арга замын эрэлхийлж * Мэргэлжилтэй ажилтан бэлтгэхэд тулгамдаж байгаа асуудал * сэдвийг сонгож авлаа.

Илтгэлийн үндсэн хэсэг .Онолын хэсэг

1.1 НҮБ-ийн хүүхдийн эрхийн конвенцид хүүхдийн амьдралыг тодорхойлох 4 үндсэн эрхийг тусгасан байдаг.

Үүнд 1. Эсэн мэнд өсөж бойжих:

- Амьдрах
- Нэр авах
- Иргэний харьяалалтай байх
- Бие хүн байх

2. Хөгжих

- Оюун ухаан авьяас билэг, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах
- Яс үндэс, арьс өнгө, хэл, нас хүйс, шашин шүтлэг, үзэл бодол, эрүүл мэндийн байдлаар ялгаварлагдахгүй байна.

3. Асарч хамгаалуулах

- Буруутай үйлдлийнхээ учир шалтгааныг тайлбарлах
- Харилцан ойлголцон эрх тэгш байдалд асуудлыг шийдэх
- Хүүхэд өөрөө учрыг нь ойлгох
- Буруу үйлдэлдээ хариуцлага хүлээх

4. Оролцох

- Өөрт зориулагдсан сургалт, эмчилгээ, үйлчилгээ, асрамж сувилалд үнэлгээ өгөх, санал бодлоо илэрхийлэх
- Хамт олон болон нийгмийн амьдралд чөлөөтэй оролцон өөрийгөө хөгжүүлэх, байр сууриа эзлэх, амьдралын орчиноо бий болгох эрхтэй .

Хүүхдийн хөгжил төлөвшил гэдэг нь бие бялдар, оюун ухаан, ажиллах чадвар, биеэ авч явах байдал, юмс үзэгдэлд хандах хандлага ба харилцаанд чанарын өөрчлөлт гарах үйл явц юм. Хүүхдийн хөгжил төлөвшил нь хоорондоо салшгүй холбоотой асуудал бөгөөд хүүхдийн хөгжил нь бие хүн болон төлөвшихөд чиглэдэг. Амьдралын бүхийл үйл ажиллагааны үр дүн болсон мэдлэг, чадвар, дээдэл, туршлага, бие хүний хөгжлийн цар хүрээ, түвшин нь хүний ерөнхий соёлыг илэрхийлнэ. Үүнийг төлөвшил гэнэ. Хүүхдийн төлөвшилд дараах хүчин зүйлүүд нөлөөлдөг.Үүнд:

1) Үдэмшлын нөлөө

2) Гадаад орчны нөлөө

3) Хувь хүн өөрийнх нь хувийн онцлог чанарууд

4) Сурган хүмүүжүүлэх зорилготой үйл ажиллагаанууд хамаарна.

Сурган хүмүүжүүлэх ухааны үүднээс авч үзвэл хүүхдэд төлөвших хүмүүжил, төлөвшил нь

дараах элементүүдийн нэгдлээр тодорхойлогддог бөгөөд бид эдгээрийг ямат нэгдмэл үйл

ажиллагаагаар тогтмол хэрэгжүүлж, хэвшил болгох шаардлагатай байдаг байна. 1. Оюун ухааны хөгжил төлөвшил: Хүүхдэд шинжлэх ухааны цэгцтэй мэдлэг олгож, тэдний танин мэдэх хэрэгцээ сонирхлыг өрнүүлж, сэтгэн бодох авьяас чадварыг хөгжүүлж, ертөнцийг үзэх үзэл, итгэл төлөвшүүлэх зорилго чиглэлтэй үйл явц, үр дүнгийн нэгдлийг оюун ухааны хөгжил хүмүүжил гэх бөгөөд энэ нь мэдэхүйн чадмжаар төлөвшинө.

2. Хөдөлмөрийн төлөвшил: Хүүхдэд хөдөлмөрт үнэнч шударга зөв хандах, зах зээлийн харилцааны чиг хандлага, хөдөлмөрийн соёлын ерөнхий мэдлэг, чадвар төлөвшүүлэхэд чиглэгдсэн сурган хүмүүжүүлэх үйл явц, үр дүнгийн нэгдлийг хөдөлмөрийн хүмүүжил гэх бөгөөд энэ нь бүтээхүйн чадмжаар төлөвшинө.

3. Ёс суртахууны боловсрол, төлөвшил: Хүн хүнтэйгээ харцах, хүн төрөлхтний ёс суртахууны үнэт чанарыг эзэмшүүлэх, төлөвшүүлэх, нийгмийн харилцааны бүхий л хүрээнд мөрдөх хэм хэмжээ, нормыг ухамсарлуулах, ёс суртахууны өндөр хариуцлагатай үйл ажиллагааг ёс суртахууны боловсрол хүмүүжил гэнэ. Энэ нь оршихуй, нийгэмшихүйн чадмжаар төлөвшилдөнө.

4. Бие бялдрын хөгжил, төлөвшил: Нийгмийн шаардлагын дагуу хүний бие махбодын зөвхөгжлийг хангах биеийн тамир, спортын мэдлэг эзэмшүүлэх зорилго чиглэл бүхий үйл явц, үр дүнг бие бялдрын хөгжил, хүмүүжил гэх ба бие бялдрын хүмүүжил нь бүтээхүй, оршихуйн чадмжаар голчлон төлөвшинө.

5. Гоо зүйн боловсрол төлөвшил: Байгаль, урлаг, уран сайхан, хүрээлэн буй амьдралын гоо сайхныг тусган үнэлж, гоо сайхны мэдрэмж, таашаал, ухамсар чадвар, дадал төлөвших үйл явц, үр дүнг гоо зүйн боловсрол гэнэ. Энэ төлөвшилд хөгжим, дүрслэх урлаг, технологийн хичээлийн цогц чадмжууд илүү нөлөө үзүүлнэ.

6. Эрх зүйн боловсрол, төлөвшил: Хүүхдэд хууль эрхийн ухамсар, соёл төлөвшүүлэх зорилго бүхий зохион байгуулалттай үйл явц, үр дүнг эрх зүйн боловсрол хүмүүжил гэнэ.

Хүүхдийн хөгжил, төлөвшилд сургууль, багш нараас гадна тэдний гэр бүл, эцэг, эх, орчин тойрны хүмүүсийн зан чанар, үзэл бодол, үйл хөдлөл маш том байр суурь эзэлдгийг мартаж

болохгүй. Иймээс эцэг, эх, сурган хүмүүжүүлэгчид өөрсдөө хүүхдийн өмнө ямагт зөв үлгэр дуурайлалтай, үлгэрлэн дагуулагч байх хэрэгтэй.

1.2 мэргэжлийн ур чадварт орчин нөлөөлөх нь

Үүнтэй зэрэгцэн мэргэжлийн ур чадвартай эрэлтэд нийцсэн бүтээгдэх гаргах нь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэн тэргүүний зорилго болж байна. Төр засгаас МСҮТ, Коллежийн багш нарын чадваржуулах, сургалтын орчинг сайжруулах арга хэмжээ авч эхэлж байна.


Тухайлбал: Манай коллежийн мэргэжлийн багш нарыг 2010 оноос 2016 оны хүртэл дотоод гадаадын мэргэжлийн дагуу мэргэжилээ тасралтгүй дээшлүүлсэн. Мөн олон төсөлд хөтөлбөрийг нэвтэрүүлж сургалтын орчноо сайжруулсан.

Үүнд: ДЗОУБ, Мянганы сорилын сан г.мэт бусад төсөлт хөтөлбөрт боловсруулж оролцож сургууль дадлагын 8 лаборатортой болж урлаг спортын заалтай болсон.

Сургалтын орчинг сайжруулснаар 2014 оны Говийн бүсийн ХММО ур чадварын тэмцээнд багш болон суралцагч нар тэргүүн байр, 2016 онд улсын хэмжээний ХММО, АЗ-ийн ур чадварын тэмцээнд сургуулийн оюутан суралцагч нар тэргүүн дэд байр эзэлж байсан. 2018 онд улсын цахилгааны *Нэмэх хасах* ур чадварын тэмцээнд тэргүүн байр эзэлж байна. Иймээс сургалтын орчин сайн байх нь суралцагч оюутаны мэргэжлийн ур чадварт нягт холбоотой байна.

Сүүлийн үед ажил олгогч суралцагчдын ур чадвараас гадна хандлага төлөвшлийг их ярьдаг болсон. Тийм дээ ч төлөвшил зөв хандлагатай сахин харьцааны соёлтой, багаар ажиллах чадвартай болгох нь сурган хүмүүжүүлэх багш бидний хариуцлага гарч ирж байна.

1. Сургалтын орчинд нөлөөлөх хүчин зүйлс




■ Дадлага газар шаардагдах тоног төхөөрөмж ■ Хөмүүрийн багаж хэрэгсэл ■ Механик гар багаж хэрэгсэл ■ Үзүүлэн самбар, бодит үзүүлэн

3. Мэргэжлийн ур чадварт нөлөөлөх хүчин зүйлс

- А. Үйлдвэрлэлийн дадлага
- Б. Дадлага газарын орчин
- В. Ур чадварын тэмцээн
- Г. Хувь хүний хандлага

1. Мэргэжлийн ур чадварт нөлөөлөх хүчин зүйлс



■ Үйлдвэрлэлийн дадлага ■ Дадлага газарын орчин ■ Ур чадварын тэмцээн ■ Хувь хүний хандлага

Дүгнэлт

Судалгаанаас үзэхэд багш суралцагчид нэг зэрэг мэргэжилтэй ажилтанг бэлтгэхэд сургалтын орчин / шаардагдах тоног төхөөрөмж , үйлдвэрлэлийн дадлага / , суралцагчдын төлөвшил хандлага гол шаардлага болж байна. Иймд зөвхөн багш суралцагч оюутаны хүмүүжил төлөвшил хандлага дээр ажиллахаас гадна эцэг , эх гол үүрэг хариуцлагатай байх нь чухал байна. Иймд ЗӨВ хандлагатай төлөвшилтэй эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтанг бэлтгэхийн тулд

Дэвшүүлж буй санаа

1. Сурган хүмүүжүүлэгч бид нар шинжлэх ухааны мэдлэг өгөхөөс гадна суралцагчдын хүмүүжил төлөвшилд нь анхаарах
2. Суралцагчдын сул талыг хэлэхээс илүү давуу талыг байнга хэлж урамшуулж байх
3. Сургалтын орчинг сайжируулах
4. Үйлдвэрлэлийн дадлагыг чанаржуулах / хугацааг богиносгох мэргэжлийн багш удирдаж явах /
5. Багш, эцэг , эх харилцаа уялдаа холбоотой байх

Ном зүй

1. Интернет мэдээлэл
2. Хүүхдийн эрхийг хамгаалах хууль
3. Мэргэжлийн боловсрол, сургалтын хууль тогтоомж
4. Мэргэжлийн боловсрол , сургалтын нийтлэл